



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 07 сарын 31 өдөр

Дугаар 6/22

Ховд

Д.Отгонтуяад ажил хавсран гүйцэтгүүлэх тухай


Хөдөлмөрийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 50 дугаар зүйлийн 50.2, 50.3 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мянган Угалзат орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дарга Н.Ганбат аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн хуулийн дагуу чөлөөлөгдөх хүсэлтээ ирүүлж ажлаас чөлөөлөгдсөн тул тус газрын даргын ажлыг 2020 оны 08 дугаар сарын 03-ны өдрөөс эхлэн Дотоод хяналтын ажилтан Д.Отгонтуяад хавсруулсугай.

2. Д.Отгонтуяад ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэл хөлсийг үндсэн цалингийн 40 хувиар тооцон сар бүр олгохыг нягтлан бодогч /Б.Батзол/-д зөвшөөрсүгэй.

3. Мянган Угалзат орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын даргын чиг үүргийг хэрэгжүүлж, Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох дүрэм журмыг мөрдөж ажиллахыг /Д.Отгонтуяа/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ